



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 7 сарын 05 өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот

Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Хорооны 2014 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх тухай журам”-ын 2.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулж буй “Саус Гоби Ложистике” хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-г зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК /Н.Монсор/-д үүрэг болгосугай.

1/ Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг зохих журмын дагуу гүйцэтгэж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөн, мэргэжлийн ёс зүйтэй ажиллах;

2/ Үүсгэн байгуулсан “Саус Гоби Ложистике” хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, сангийн нэгж эрхийн танилцуулгад нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд Хороонд тухай бүр мэдэгдэн холбогдох баримт бичгийг бүртгүүлэх;

3. Энэ тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН